



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Алтай хот

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:**

Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1. Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд3
1.2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:3

Хоёр. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

- 2.1.Хэлтсээс зохион байгуулсан ажил,үйлчилгээ.....3-5
2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл,нийгмийн баталгааг хангах чиглэлээр.....5-6
2.3 Тоон гарын үсэг6
2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн ажил6-7
2.5. УБЕГ-аас гарсан тушаал, шийдвэр өгсөн чиглэл, үүрэг даалгавар7

Гурав. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:.....8-9
3.1. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд9
3.2. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:.....9

**Дөрөв. ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР.....9-11**

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:11

Зургаа. ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:.....11-12

Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР12-13

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР13

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:13-15

Арав. ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:.....15-16

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:16-18

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

2023.11.17

Алтай хот

Нэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлага болгон хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг 18 сум 88 багийн 58.400 гаруй иргэнд хүргэн ажиллалаа.

2023 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай 5 зорилтын хүрээнд 25 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн Засаг даргатай 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус боловсруулан, батлуулж, биелэлтийг ханган ажиллалаа.

1.2 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн Б/424 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, улсын бүртгэгч 25, архивч 1, нярав, бичиг хэргийн ажилтан 1, ахлах нягтлан бодогч 1, архивч, мэдээллийн технологийн ажилтан 1, гэрээт ажилтан 5 зэрэг нийт 38 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хэлтсээс зохион байгуулсан ажил:

➤ 2023 оны ХАСХОМ-ийг мэдүүлэх ёстой 28 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 01 сарын 21-нд багтаан сүлжээнд бүрэн шивүүлж, баталгааны маягыг гаргуулан авч баталгаажуулан хадгалсан болно. Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар иргэдээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй. Хөрөнгө орлогоо мэдүүлэхээс татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй.

➤ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авлаа.

➤ Улсын бүртгэлийн байгууллагаас 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн үндэсний энгийн цахим гадаад паспортын захиалга авахдаа үйлчилгээний хураамжийг пос машинаар тушаалгаж, цээж зураг шаардахгүйгээр тухайн хэлтсийн бүртгэгч өөрөө цээж зургаа авч бүртгэлийн системд оруулан үйлчилгээ үзүүлж байна.

➤ Хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, болон тулгамдаж буй асуудал, УБЕГ болон Аймаг орон нутгийн удирдлага, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулан ажилласан. Тайлант хугацаанд нийт 26 удаагийн онлайн хурал зохион байгуулсан байна. Үүнд: УБЕГ-

аас өгсөн үүрэг чиглэл, Шинэ програм, тоон гарын үсэг, гадаад паспортын зураг авалт бусад цаг үеийн асуудлуудаар/

➤ 2023 оны 3 дугаар сарын 05-ны өдөр тус хэлтэст гэрээт жолоочоор ажиллаж байсан Д.Гансүх, гэрээт үйлчлэгч Б.Отгончимэг нарт хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулав.

➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн болон “Үндэсний мод тарих өдөр”-ийн хүрээнд 2023.05.13-ны өдөр Хэлтсийн албан хаагчид Шүтээний өндөрлөгийн баруун талд 100 ш хайлаас, 2023.10.13-ны өдөр хэлтсийн гадна талд 12 ш шар хуайсыг тус тус тарилаа.

➤ Тус хэлтсийн Улсын ахлах бүртгэгч Я.Арвижих, Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэн нар 2023 оны 09 сарын 6,7,8-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон E-Mongolia платформд байршсан улсын бүртгэлийн үйлчилгээнүүд, Тоон гарын үсгийн ач холбогдлын талаар Ёсөнбулаг сумын Ерөнхий боловсролын 12 жилийн 1,2,3 дугаар сургуулийн ахлах ангийнханд мэдээлэл өгч ТАНИН МЭДЭХҮЙН “АХА” тэмцээнийг зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйлээр урамшууллаа

➤ 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П. Сайнзоригор ахлуулсан ажлын хэсэг ирж Хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж хэлтэст тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэж өгөхөөр болсон .

➤ Тус хэлтсээс иргэн Ганболдын Энхням, Ганзоригийн Мөнгөнтуяа, Мөнхбаатарын Адъяасүрэн, Ганпүрэвийн Отгонсүрэн нарын залуу хосуудын гэрлэх ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

➤ Хэлтсийн даргын 2023.10.02-ны өдрийн А/11 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтанд тооллого хийж тайланг Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт хүргүүлсэн.

➤ 2023 оны 10 сарын 17-ны өдрөөс 24-ны өдрүүдэд Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг, ХЭЭХУБТ-ийн дарга, Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа нар тус аймгийн Бугат, Төгрөг, Шарга, Тонхил, Дарив, Жаргалан, Баян-Уул сумдад томилолтоор ажиллаж иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 58 мэдүүлэг, хуулийн этгээдийн бүртгэлийн 16 бүртгэлийг тус тус хүлээн авч газар дээр нь бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. Хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг тус сумдын улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

➤ E-MONGOLIA сайтад орсон улсын бүртгэлийн үйлчилгээнүүд болон Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, тоон гарын үсгийн ач холбогдлыг иргэдэд таниулах зорилгоор Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэн Аймгийн Засаг Даргын ажлын хэсэгт орж Тайшир, Дэлгэр, Эрдэнэ, Чандмань, Хөхморьт, Баян-Уул,Жаргалан, Төгрөг, Бугат, Халиун, Цээл, Цогт сумдад 2023.09 сарын 18-наас 10 сарын 18-ны өдрүүдэд ажиллаж Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, E-Mongolia цахим сайтад байршуулсан улсын бүртгэлийн үйлчилгээ болон тоон гарын үсгийн ач холбогдлын талаар нийт 6700 гаруй иргэнд мэдээ мэдээлэлийг хүргэж 183 иргэнд тоон гарын үсэг олгож 3 иргэний бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэж ажиллалаа.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдөр Хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Тайшир суманд ажиллаж бүртгэлийн цахим үйл ажиллагааг сурталчилж 9 иргэнд үйлчилгээ үзүүлж 53 иргэнд тоон гарын үсэг тус тус олголоо.

➤ 2023 оны 1,2,3 дугаар улиралд Аймгийн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албаны ерөнхий шалгалтад орж байгаа иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу хурууны хээний бүртгэлийг хийж хамтран ажилласан.

➤ УБЕГ-аас “Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн ой”, “Бүртгэлийн ажилтны баяр-2023” арга хэмжээний хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 16-наас 19-ны өдрүүдэд зохион байгуулсан спортын арга хэмжээнд тус хэлтсээс 8 албан хаагч оролцож гэрээт ажилтан Ч.Цэрэндаваа теннисний төрөлд хүрэл медаль, сагсан бөмбөг болон гар бөмбөгийн төрөлд Улсын бүртгэгч Ч.Угтахбаяр, Э.Цэрэндулам нар оролцож тус тус Алтан медаль хүртлээ.

➤ Тус хэлтсээс 2023 оны 11 дүгээр сарын 23, 24-ны өдрүүдэд “Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 83 жил”-ийн ой, “Бүртгэлийн ажилтны баяр-2023” арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу тэмдэглэн өнгөрүүлээ.Энэ арга хэмжээний хүрээнд албан хаагчдын дунд гар бөмбөг, дартс, олс таталтын тэмцээн явуулж байр эзлүүлэн шагнасан. Удирдлагын академийн багш доктор, профессор Т.Алтанцэцэгээр “Хувь хүний ёс зүй, харилцаа” сэдвээр 2 цаг, УБЕГ-ын Нэгдсэн архивын газрын мэргэжилтэн Б.Дуламсүрэн 2 цагийн онлайн сургалтыг хөтөлбөрийн дагуу тус тус явууллаа.

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:

➤ Хэлтсийн албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргаж, УБЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу шагнуулах албан хаагчдыг хамт олны хурлаар хэлэлцэн шагналын материалыг 2023 оны 01 сарын 17-ны өдрийн №09 тоотой УБЕГ-т шийдвэрлүүлэхээр хүргүүлэн 2023.07-р сард Улсын бүртгэгч Г.Гантулга, Б.Рэнцэндорж нар УБЕГ-ын жуух бичгээр, 2023.11 сард хяналтын Улсын байцаагч Д.Оюунчимэг “Хууль зүйн тэргүүний ажилтан”, ня-бо Б.Алтанбагана нар Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух” бичгээр тус тус шагнагдлаа.

➤ Тус хэлтсийн Дэлгэр сумын улсын бүртгэгч Сандивын Буянтогтохийн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлүүлэхээр УБЕГ-ын Тамгын газарт хүргүүлж 500.000 төгрөгний буцалтгүй тусламж олгуулсан.

➤ Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс зохион байгуулсан хандивын аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж, Улсын бүртгэгч С.Баттулгад 670.000 төгрөгний хандив, Увс аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 125000 төгрөгний хандивыг тус тус цуглуулан хүргүүлсэн

➤ Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2023.03.11-ны өдөр болон 10 сарын 8,9-ны өдрүүдэд аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж нийт 30 албан хаагч хамрагдав.

➤ Идэвхтэй амралт, аялалын арга хэмжээг бүх албан хаагчдыг хамруулан 2023.01 сард Олоннуурт, 2023.09 сард Хүнхэрийн амралтанд тус тус зохион байгуулсан.

➤ 2023 оны 6 сард Хэлтсийн байранд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зайлшгүй хийх шаардлагатай засварыг хийж үйлчилгээний танхим 2 давхарт байрлан үйл ажиллагаа явуулж байсныг 1 давхарт нүүлгэн байршууллаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих зориулалтын зам, шатыг хийлээ.

➤ 2023 оны 05 сард Хэлтсийн архивыг өргөтгөж УБЕГ-аас архивын хөдөлгөөнт том сейф 2, төмөр тавиур 4 ш тус татан авчирч архивт байршууллаа. Архивын галын буланг шинэчилж камерийн хяналтын дэлгэцийг жижүүрийн өрөөнд суурилуулав. Мөн архивын 3 цонхны хөшгийг стандарт шаардлагад нийцсэн хөшгөөр солив.

➤ Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд Хэлтсийн гадна автомашины зогсоолыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан засварлаж 25 автомашин зогсох зогсоолыг шинээр бий болголоо. Мөн гадна хайсны суурийн өнгө үзэмжийг сайжруулж 12 мод тарилаа.

➤ 2023 оны 10 дугаар сарын 02-ны “Ахмадын баяр”-ын өдөр хэлтсийн ахмад настан Х.Нанжид, Л.Алтанцэцэг, Б.Амгалан, Р.Сэр-од нарт хүндэтгэл үзүүллээ.

➤ Зүрхний хүнд өвний улмаас хагалгаанд орсон тус хэлтсийн Жаргалан сумын улсын бүртгэгч Х.Нэргүйд УБЕГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Б/502 тоот “Нэг удаагийн мөнгөн тусламж олгох тухай” тушаалаар 1.000,000 төгрөгийг буцалтгүй тусламжаар олгож, хамт олны зүгээс 2.000.000 төгрөгийг сайн дураараа эмчилгээний төлбөрт нь хандивласан.

➤ 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Хэлтсийн 37 албан хаагч тус аймагт хэрэгжиж буй "Ид шид"-ийн орон төсөлд 740.000 төгрөгийн хандив өргөлөө.

2.3 Тоон гарын үсэг:

➤ Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд фэйсбүүк хаягийн профайл зургийн хүрээг шинээр хийж хэлтсийн албан хаагчдын фэйсбүүкийн нүүр зургийг сольсон.

➤ Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Тоон гарын үсгийн ач холбогдлын талаархи мэдээлэл өгөх сургалтыг 57 байгууллагын 11000 гаруй сурагч, оюутан, албан хаагч нарт хүргэж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Мөн тоон гарын үсгийн ач холбогдол бүхий мэдээ мэдээллийг аймгийн төв талбайн дэлгэцээр байнга сурталчилж нийт 5200 гаруй иргэнд мэдээллийг хүргэж тоон гарын үсэгтэй холбоотой ярилцлагыг фэйсбүүкийн лайв сурвалжлагаар 4 удаа хийлээ.

➤ 2023 оны 4 сарын 03-ны өдрөөс УБЕГ Хаан банкт хамтран хэрэгжүүлсэн иргэдэд тоон гарын үсэг олгох 3 сарын аяны хүрээнд Аймгийн Хаан банкны удирдлагатай аяны хүрээнд хамтран ажиллах төлөвлөгөө гарган баталж хэрэгжилтийг ханган ажиллаж 6251 иргэнд тоон гарын үсэг олголоо.

➤ УБЕГ-аас өгсөн Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх чиглэлийн дагуу төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон сумдын Засаг дарга нартай хамтран автомашины улсын үзлэг, ээлжит цэрэг татлагын үеэр иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулж 118 иргэнд тоон гарын үсэг олголоо. Мөн аймгийн төвийн сургуулиудтай хамтран 2023 онд 16 насанд хүрсэн сургуулийн сурагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулж ажиллалаа.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Аймгийн Төрийн аудитын газрын дарга Г.Гүнжидмаа, ахлах аудитор Эрдэнэчимэг, аудитор Сүнжидмаа нарыг Хэлтэст урин ирүүлж “Төрийн хяналт шалгалтын тухай хууль” журам болон тус хэлтсийн улирлын 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийж байгаа улирлын гүйцэтгэлийн Аудитын шалгалтын талаар санал бодлоо солилцлоо.

➤ Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сар 22-ны өдрийн тоот А/13 тоот тушаалаар 31 албан хаагчид 2023 оны 1,2 дугаар улирлын үр дүнгийн гэрээний урамшууллыг олголоо.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар нийт 24.200 иргэнд тоон гарын үсэг олгож 60,5 хувьтай байна.

2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн ажил:

➤ Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран саатуулагдаж байгаа 1 иргэнд цахим иргэний үнэмлэх олголтын бүртгэл, 1 иргэний гэрлэлтийн үйл ажиллагааг зохион хамтран зохион байгуулж гэрчилгээ, батламжийг гардууллаа. Мөн ял эдэлж байгаа 3 иргэнд тоон гарын үсэг олголоо.

➤ Аймгийн Засаг даргын 2023.03.31-ны өдрийн А/170 тоот захирамжаар байгуулагдсан “Авто тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах тухай” ажлын хэсэгт тус хэлтсээс ажиллаж үзлэгт хамрагдахаар ирсэн иргэдэд тоон гарын үсэг олгож ажиллав.

➤ Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар 2023.05.31-ны өдөр тус хэлтсийн албан хаагчидтай ажил хэргийн уулзалт зохион байгуулж энэ үеэр албан хаагчдад

газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэж 11 албан хаагчид гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олголоо.

➤ Хүний эрхийг хангах ажлын хүрээнд тус хэлтэс Аймгийн ШШГГ, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай тус тус хамтран бичиг баримтаа үрэгдүүлсэн 12 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж бичиг баримтжууллаа.

➤ Улсын бүртгэлийн “Нээлттэй өдөр” арга хэмжээг:

-2023.03.16-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газар

-2023.04.07-ны өдөр аймгийн ХААН банк

-2023.04.21-ны өдөр Аймгийн ХХҮГ, Нийгмийн датгалын хэлтэс

-2023.05.09-ны өдөр ШШГГ, Цагдаагийн газар

-2023.10.09-ны өдөр Аймгийн Төрийн байгууллагууд

-2023.10.17-21-ны өдрүүдэд Шарга, Төгрөг, Бугат сумдад аймгийн Татварын хэлтэс зэрэг байгууллагуудтай тус тус хамтран зохион байгууллаа.

-Нээлттэй өдөрлөгүүдийн үеэр иргэдэд Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний талаар мэдээллийг өгч нийт 622 иргэн, 49 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэж 2300 иргэнд тоон гарын үсэг олголоо.

➤ Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын Шадар сайдын

Говь-Алтай аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль”-ийг тус аймагт 4 сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулж тус хэлтэс чиг үүргээр хүлээсэн үүргийн дагуу оролцож аймгийн Онцгой комиссыг мэдээ мэдээллээр хангасан.

➤ Аймгийн Засаг даргын 2023 он 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/198 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу сум, байгууллагын төрийн албан хаагч, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын дунд үндэсний бичгийн “Цахим бичвэр”-ийн уралдааныг 5 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Уг уралдаанд 51 байгууллагын 104 албан хаагчид оролцож өрсөлдсөнөөс Улсын бүртгэгч Д.Гүндэгмаа оролцож 3-р байр эзлэн шагнууллаа.

➤ Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр тус аймагт зохион байгуулагдаж нийт 22 албан хаагч хэлэлцүүлэгт оролцож саналаа илэрхийлсэн.

➤ Монгол Улсын Засгийн газар, Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-ны нэг арга хэмжээ болох “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог ханган хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх аянд Улсын бүртгэлийн хэлтэс нэгдсэн.

➤ 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдөр гэрлэх ёслол хүндэтгэлийн арга хэмжээг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын хөгжлийн төв, Улсын бүртгэлийн хэлтэс, Ардын дуу бүжгийн Алтай чуулгаас хамтран зохион байгуулав.

2.5 УБЕГ-аас гарсан тушаал, шийдвэр өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилт:

УБЕГ-аас нийт 147 албан бичиг ирснээс тушаал 37, хугацаат чиглэл, үүрэг даалгавар 42, бусад 68 албан тоот бичгээр хариуг тогтоосон хугацаанд гаргаж хариуг хүргүүлж ажилласан болно.

Гурав: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Улсын бүртгэлийн ерөнхий газраас батлагдсан “Албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-тэй уялдуулан Хэлтсээс сургалтын үйл ажиллагааны 2023 онд хэрэгжүүлэх 9 заалт бүхий арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажил 100 % бүрэн хэрэгжсэн.

3.1. Улсын бүртгэлийн ерөнхий газраас онлайнаар зохион байгуулсан сургалт:

➤ 2023 оны 02 сарын 03-ны өдөр Үндэсний энгийн цахим гадаад паспортыг хэрэглээнд оруулахтай холбоотой цахим сургалтанд Улсын ахлах бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтан нар

➤ 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Авлигатай тэмцэх газраас нийтийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан онлайн сургалт Н.Золжаргал Г.Баасанжаргал Б.Тогтохбаяр Д.Алтанцэцэг нар

➤ 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагын Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтанд Э.Баатарсүрэн Э.Цэрэндулам С.Баянаа нар

➤ 2023 оны 02 дугаар сарын 24-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулах онлайн сургалтанд бүх алба хаагчид

➤ 2023 оны 03 дугаар сарын 11-ны өдөр “Шударга байдлын үнэлгээний дүн танилцуулах” онлайн сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц

➤ 2023 оны 03 дугаар сарын 13-ны Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад зориулсан эрх зүйн онлайн сургалтанд бүх албан хаагчид

➤ 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдөр ХЭУБГ-с эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч нарт зориулсан сургалт Б.Энхзаяа нар

➤ 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн танилцуулга, хэлэлцүүлэгт хэлтсийн 32 албан хаагч

➤ 2023 оны 6 дугаар сарын 05-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдвээр зохион байгуулсан сургалтанд 21 албан хаагч

➤ 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан онлайн сургалтанд 26 албан хаагч.

➤ 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц, ХЭЭХУБ-ийн тасгийн дарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа нар

➤ 2023.10.25-ны өдөр УБЕГ-ын БТДШГ-аас зохион байгуулсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журмын танилцуулах сургалтанд хэлтсийн 23 албан хаагч

➤ 2023 оны 10 сарын 31-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан "Хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг дээшлүүлэх" сэдэвт сургалтанд 21 албан хаагч

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилго бүхий сургалтыг зохион байгуулахаар өгсөн чиглэл, хөтөлбөрийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 31-ны өдөр цахим сургалтыг зохион байгуулж 29 албан хаагч хамрагдлаа.

➤ Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2023.10.20-ны өдрийн 2/9641 тоотой өгсөн Хүний нөөц сургалтын программ дээрх Бие даах хичээлийг үзэж судлах тал дээр тодорхой арга хэмжээ авч ажиллах тухай чиглэлийн дагуу албан хаагчдад хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг ханган ажиллалаа Төрийн захиргааны 28, төрийн үйлчилгээний 4 албан хаагч нийт 135 хичээл үзэхээс ТЗ-ны албан хаагч 108 хичээл, төрийн үйлчилгээний албан хаагч 14 хичээл судалсан байна. Хэлтсийн бие даах хичээл үзсэн байдлын биелэлт 90,3% -тай байна.

3.2. Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт:

2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Авлигаас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид

➤ 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин” онлайн сургалт бүх алба хаагчид

➤ 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага” онлайн сургалтанд 9 албан хаагч

➤ 2023 оны 03 дугаар сарын 02-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагч” онлайн сургалтанд 28 албан хаагч

➤ 2023 оны 03-р сарын 17-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Албан тушаалын тодорхойлолт” онлайн сургалтанд 20 албан хаагч

➤ 2023 оны 03-р сарын 30-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Үндсэн хуулийн үзэл баримтлал” онлайн сургалтанд 17 албан хаагч

➤ 2023 оны 04-р сарын 06-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтанд 11 албан хаагч

➤ 2023 оны 04-р сарын 27-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтанд 3 албан хаагч

➤ 2023 оны 05-р сарын 11-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтанд 6 албан хаагч тус тус хамрагдлаа.

➤ 2023 оны 10-р сарын 19-нд Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтанд 8 албан хаагч

3.2. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалт:

➤ 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Орон нутаг дахь төрийн албан хаагчдад зориулсан зориулсан “АПСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын богино хугацааны сургалтанд 5 албан хаагч хамрагдаж сертификат авсан.

3.3. Хэлтсээс зохион байгуулсан сургалт:

➤ 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсээс “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар” онлайн сургалт зохион байгуулж төрийн захиргааны 21 албан хаагч

➤ Тус хэлтсээс Монгол Улсын Их Хурлын 2022 онд шинээр баталсан болон өөрчлөлт орсон хуулиудаар 2023.03.26,27-ны өдөр зохион байгуулсан цахим сургалтанд 20 албан хаагч

➤ 2023.04.04-ны өдөр зохион байгуулсан хэлтсийн албан хаагчдын нэгдсэн цахим сургалтанд 20 албан хаагч тус тус хамрагдлаа.

➤ Тус хэлтсээс 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион явуулсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” –ын талаархи онлайн сургалтанд 16 албан хаагч

➤ 2023.10.13-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах сургалт зохион байгуулж шалгалт авав.

Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1. Мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр:

➤ Цахим хаяг: <https://govi-altai.burtgel.gov.mn/>

➤ Фэйсбүүк хаяг: /Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс/

- Фэйсбүүк хаяг: /GAA-н UBHeltes/ /байгууллагын албан хаагчид зөвхөн орох, дотоод албан бичиг, мэдээ мэдээлэл солилцох/:
- Вэб хуудасны хөгжүүлэлт:
- Хуудасны баннер цэсийг нэгдсэн загварт оруулж холбогдох линкийг холбосон.
- Албан хаагчдын мэдээлэл, газар орны мэдээллүүдийн өөрчлөлтийг тухай бүр нь шинэчлэсэн.
- Вэб-д оруулах бүх цэсэнд тохирсон мэдээллүүдийг хугацаанд нь байршуулсан.
- Вэб-д оруулсан мэдээллийн линкийг байгууллагын фэйсбүүк хаягаар дамжуулан байнга сурталчлан ажилласан.

Вэб хуудасны ангилал	Оруулсан мэдээний тоо
Санхүүгийн ил тод байдал	48
Хурал, сургалт семинар, хэлэлцүүлгийн зар	17
Жил улирлын тайлан	11
Нээлттэй ажлын байрны зар	0
Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал	24
Сар бүрийн тоон мэдээлэл	40
Түгээмэл асуулт хариулт	23
Цаг үеийн мэдээ	129
Видео мэдээ	42
Топ мэдээ	36
Нийт байршуулсан мэдээ	393

4.2. Сурталчилгааны чиглэлээр:

➤ Аймгийн Засаг даргын иргэд малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхайгаар оршин суугаа газар нутагт нь хүргэх ажлын хүрээнд Мэдээлэл технологийн ажилтан Э.Баатарсүрэн 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хооронд нийт 3 удаагийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

➤ Уг ажлын хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, E-Mongolia цахим сайтад байршуулсан улсын бүртгэлийн үйлчилгээ болон тоон гарын үсгийн ач холбогдлын талаар нийт 6700 гаруй иргэнд мэдээ мэдээлэлийг хүргэж 183 иргэнд тоон гарын үсэг олгож 3 иргэний бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэж ажиллалаа.

➤ Байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн цахим хуудас, фэйсбүүк хаяг болон аймгийн телевиз радиогоор болон үйлчилгээний зааланд байрлуулсан LCD зурагтаар дамжуулан иргэдэд түргэн шуурхай мэдээлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

➤ Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, тоон гарын үсэгтэй холбогдуулан “live сурвалжлага “ 3 удаа хийж иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн байна.

➤ Бүртгэлийн үйлчилгээний үнэ тариф, бүрдүүлэх нотлох баримт бичиг, үйлчилгээний хөлс тушаах дансны мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх улсын бүртгэгчийн мэдээлэл, үйлчилгээ авах цэг, хаяг байршлыг агуулсан самбарыг үйлчилгээний танхимд байршууллаа.

4.3. Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

➤ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ийн дагуу үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

- Албан хаагчдын компьютерийн плаш оролтуудыг бүрэн хааж, аюулгүй байдлын санамжийг компьютер болгон дээр наасан.
- Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг 14 хоногоос 1 сарын дотор солиулж, бүртгэл хөтлөн ажиллаж байна.
- Хэлтсийн архив, сүлжээ сервер болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлчилгээний заал, коридор, архивын гадна дотор хаалга, сургалтын заалыг бүрэн камержуулсан. Хянах дэлгэцийг харуулын өрөөнд байрлуулсан.
- Үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютер, процессорыг эрсдэлээс урьдчилан “УБЕГ” лацаар лацдаж бүртгэл хөтөлсөн.
- Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагддаг 9 компьютерийг BITDEFENDER вирусны жилийн лицензтэй програмаар хамгаалсан..

4.4. Сервер, компьютер тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ:

- Хэлтсийн серверийн рөүтерийг МТГ-аас Sophos router-ээр шинэчлэсэн. Одоогоор үйл ажиллагаа хэвийн жигд явагдаж байна.
- Хэлтсийн төв сервер болон Нэг цэгийн үйлчилгээний газрын сүлжээний дамжуулагч Convertor /нийт 4 ширхэг/-уудыг өөрсдийн бололцоонд тулгуурлан бүрэн шинэчлэсэн.
- Серверийн өрөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж давхар цоож, лацаар лацадсан, хаалга хэсгийг камерын харах өнцөгт оруулсан.

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2023 оны жилийн эцсийн байдлаар Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 501 албан бичиг ирсэнийг зохих журмын дагуу бүртгэн авч холбогдох ажилтнуудад шилжүүлэн, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Үүнээс 315 хариутай албан бичиг ирсний хариуг тухай бүрт нь шийдвэрлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн тайлангийн хугацаанд 610 албан бичгийг зохих стандарт, журмын дагуу боловсруулан холбогдох албан байгууллага, иргэдэд хүргэж ажилласан.
- Тайлант хугацаанд тус хэлтэст иргэн, хуулийн этгээдээс нийт 99 өргөдөл, санал, хүсэлт ирснийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж 100% шийдвэрлэн иргэдэд хариуг өгч ажилласан. Хугацаа хоцорч шийдвэрлэсэн өргөдөл, санал хүсэлт байхгүй.

Зургаа. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2023 оны жилийн эцсийн байдлаар төрсний бүртгэл-913, гэрлэлт-264, үрчлэлт-19, эцэг тогтоолт-48, овог нэр нэр өөрчлөлт-49, нас баралт-262, гэрлэлт цуцлалт-21, иргэний үнэмлэх шинээр болон дахин 2368, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлээр аймаг нийслэлээс ирсэн-271, аймаг доторх шилжилт хөдөлгөөний бүртгэлээр-756 бүртгэл хөтлөж бүртгэл тус бүрийг хууль заасан нотлох баримт 7894 хуудас баримт цахимжуулсан.
- Үндэсний энгийн болон цахим гадаад паспорт авах -2488 иргэний хүсэлтийг хүлээн авч цахим гадаад паспорт-951, энгийн паспорт- 1537 баталгаажуулан, хэвлэгдэн ирсэн гадаад паспортыг иргэдэд тухай бүрд нь олгож ажилласан. Цахимжуулсан хуудас-2140
- Архивын чиглэлээр иргэд, хуулийн этгээд болон албан хэрэгцээнд зориулж нийт-3781 лавлагаа гаргаснаас иргэдэд-2245, хууль хяналтын байгууллагын албан тоотоор-925, албан хэрэгцээнд-611 лавлагааг тус тус гаргаж, иргэний баримтын архивын хувийн хэргийн санд-4818 иргэний хувийн хэргийг шинээр үүсгэж, ИУБ-11-ИУБ-18 ИУБ-31 маягт 3665 төрөлжүүлэн байрлуулж, бусад аймаг хотруу шилжин явсан-800, хувийн хэргийг ялган шилжүүлж, аймаг хотоос шилжин ирсэн-27 иргэний хувийг хэргийг галиглан байршуулсан.

- Сарын мэдээг нэгтгэн гаргаж холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэн ажилласан.
- Тоон гарын үсгийг иргэдийн хүсэлтээр байнга олгож, УБЕГ ХААН- банктай хамтран тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяны хүрээнд 18 сумд “Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулсан. Тоон гарын үсэг авах иргэдийн 60,5 хувь буюу 24.200 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.
- Тус аймгийн нэг хаяган дээрх 10-аас дээш оршин суугчидтай өрхийн мэдээллийг 2 удаа багийн дарга болон тухайн сумын улсын бүртгэгч нартай хамтран өрхийн бүртгэлтэй тулган хаягийн судалгааг нэгтгэн хугацаанд нь илтгэх хуудсаар хүргүүлж ажилласан.
- Иргэний бүртгэлийн газраас өгсөн чиглэлийн дагуу мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд ирүүлсэн ИУБ-11-22 маягтуудын бүртгэлийг архивын баримттай тулган шалгаж, давхар шивэгдсэн, бүртгэлийн төрөл буруу сонгосон бүртгэлүүдийг шалгаж УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас гаргасан нэгдсэн дүгнэлтийн дагуу нөхөн бүртгэл засвар өөрчлөлтийн бүртгэлээр -200 иргэний зөрчлийг арилгаж, Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн мэдээллийн санд зөрчилтэй 140 иргэний зөрчлийг Хяналтын улсын байцаагчтай хамтран ажиллаж 35 иргэнд дүгнэлт гаргуулан холбогдох газруудад илтгэх хуудсаар хүргүүлсэн.

Долоо.ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2023 онд иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 3679 мэдүүлэг хүсэлтийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэв. Үүнд газраас бусад үл хөдлөх хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн 139, төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн 191, худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 286, бэлэглэх гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх 141, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 73, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 43, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээгээр шинэ бүртгэл үүсэх 38, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 2, барьцаат зээлийн гэрээний 1408, барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгох 1086, лавлагаа хуулбар олгох 114, бүртгэлд өөрчлөлт оруулах 126, бусад гэрээний 4, гээгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 16, бүртгэл хаах 12 бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэлээ.
- Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар иргэн, хуулийн этгээдээс 65,202,372 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 3,378,605 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварын орлого 205,149,790 төгрөг тус бүрийг улсын болон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.
- Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр хийгдсэн бусад ажил:
- Бүртгэлийн тоон мэдээг сар бүрийн 26-ны өдөр ЭХЭУБГазар болон ХЭУБГазарт, үнэт цаасны болон орлогын тайланг сар бүрийн 26-ны өдрөөс хойш хэлтсийн санхүүд, улсын тэмдэгтийн хураамжийн тайланг 1 удаа санхүүд хугацаанд нь нэгтгэн тайлагналаа.
- 2023 онд эд хөрөнгийн цахим мэдээллийн санд буруу боловсруулсан, алдаатай цахимжуулсан, зурган мэдээлэл нээгдэхгүй байсан 89 бүртгэлийн 115 алдаатай мэдээлэл зассан 2 удаагийн засвар өөрчлөлтийн тайланг файл хэлбэрээр ЭХЭУБГазарт хүргүүлэв.
- 2023 оны 9,10,11-р сарын эд хөрөнгийн эрхийн хаасан бүртгэлийн тайланг ЭХЭУБГазарт хүргүүлэв.
- ЭХЭУБГазраас ирүүлсэн 6/277 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 1 сарын 11-ны өдөр, 5/1854 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 3 сарын 10-ны өдөр, 5/4053 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 5 сарын 19-ний өдөр, 5/4664 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 5 сарын 16-ны өдөр, 5/7503 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 8 сарын 25-ны өдөр,

5/10589 тоот албан бичгээр ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг 11 сарын 22-ны өдөр тус тус илтгэх хуудсаар хүргүүлэв.

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

➤ 2023 онд хуулийн этгээдийн бүртгэлийн 481 хүсэлт хүлээн авч хугацаанд нь 100% шийдвэрлэв. Үүнд шинээр хуулийн этгээд байгуулах 78, мэдээлэлд өөрчлөлт оруулсан 196, тамга тэмдгийн дугаар олголт 48, лавлагаа хуулбар олголт 60, татан буугдах бүртгэл 3, салбар төлөөлөгчийн газрын бүртгэл 13, дахин гэрчилгээ олголт 33, оноосон нэр баталгаажуулах 63, оноосон нэр сунгалт 3 тус тус хийж гүйцэтгэлээ.

➤ Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар 4,059,480 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар 6,264,520 төгрөг тус бүрийг улсын болон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

9.1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

➤ Тайлант онд шинээр нээсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 162, газар өмчлөх эрхийн 179 хувийн хэрэг нийт 341 хувийн хэрэг архивт хүлээн авч бүртгэл хөтлөн байршуулсан. 3459 хувийн хэргийн эх нотлох баримтыг бүртгэгч нараас хүлээн авч хувийн хэрэг тус бүрт хийсэн.

➤ 2023 оны 11 сарын 26 байдлаар тус архивт газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 5554 ш хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 5060 ш хувийн хэрэг, хадгалагдаж байна. Одоогийн байдлаар тус архивт байнга хадгалах бүртгэлийн дэвтэр 209 х/н, түр хадгадагдах 142 дэвтэр хадгалагдаж байна.

9.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

➤ Хуулийн этгээдийн архивт 2023 оны 11 сарын байдлаар шинээр бүртгэл үүссэн 72 хуулийн этгээдийн хувийн хэрэг хүлээн авч бүртгэн архивт байрлуусан. Татан буугдсан 103 хуулийн этгээдийн хувийн хэргийг ялгаж, шилжин явсан 2 хуулийн этгээдийн хувийн хэргийг шилжүүлсэн. Нийт 1457 хувийн хэрэг хадгалагдаж байна.

➤ Бүртгэгчээс 250 эх нотлох баримтыг хүлээн авч хувийн хэрэгт байрлуулсан.

➤ Тус архивт татан буугдсан хуулийн этгээдийн хувийн хэрэг 155 хадгаламжийн нэгж, Тамга тэмдэг хураасан тухай баримт 18 хадгаламжийн нэгж, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 32 аж ахуй нэгжийн хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна. Хэлтсийн даргийн 2023 оны 10 дугаар сарын 02 ны өдрийн А/1300 дугаар тушаалын дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хувийн хэрэгт 2023 оны 10 сарын 03 ны өдрөөс тооллог хийж хувийн хэргийн цаасан эх нотлох баримтыг цахим мэдээллийн сантай тулгаж шалган тооллогийн ажлыг бүрэн хийж дуусгасан. Тус архивт нийт 1457 хуулийн этгээдийн 53904 хуудас хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнд:

510	хувьцаат компани	2	144
511	хязгаарлагдмал хувьцаат компани	845	27855
512	төрийн өмчит хувьцаат компани	1	99
513	төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	1	22
514	орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	13	518
515	банк бус санхүүгийн байгууллага	1	38
520	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	71	2840
521	зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	25	1500
525	боловсорол соёлын байгууллага	1	23
530	хоршоо	111	6600

531	хадгаламж зээлийн хоршоо	12	635
569	төрийн байгууллага албан газар	95	3325
568	улсын төсөвт үйлдвэрийн газар	31	1395
570	улсын төсөвт үйлдвэрийн газар	68	2380
571	нийтэд үйлчилдэг төрийн бус байгууллага	103	4250
572	гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага	33	977
573	хэвлэл мэдээллийн хэрэгсэл	1	25
574	үйлдвэрчний эвлэлийн байгууллага	13	347
578	холбоо	21	672
580	шашны байгууллага	3	103
581	сан	5	136
509	Хэвлэл мэдээл ххк	1	20

9.3. Иргэний улсын бүртгэлийн архив:

➤ Тус архивт тайлант хугацаанд 4818 ширхэг ИУБ маягт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан сан тус бүрт байршуулсан. Үүнд: ИУБ-11 маягт 988, ИУБ-12 маягт 13, ИУБ-13 маягт 46, ИУБ-14 маягт 42, ИУБ-15 маягт 249, ИУБ-16 маягт 19, ИУБ-18 маягт 207, ИУБ-31 маягт 2357, ИУБ-21 маягт 1948 ширхэгийг тус тус хүлээн авсан.

➤ 2023 онд шилжин явсан 101 иргэний хувийн хэргийг архивын сангаас татан авч харъяа газарт нь хүргүүлсэн.

➤ Шилжин ирсэн 30 иргэний хувийн хэргийг хууль журмын дагуу хүлээн авч бүртгэл хөтлөн цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан архивт байршуулсан.

➤ 2023 онд иргэний улсын бүртгэл хийхэд бүрдүүлсэн анхан шатны баримт болон бүртгэлийн дэвтэр 110 хадгаламжийн нэгжийг хүлээн авч бүртгэн ИГБББ-ийн санд байршуулсан.

➤ “ИГБББ сан”д нийт 1488 хадгаламжийн нэгж, “Хувийн хэргийн нэгдсэн сан”д 64,860 иргэний ХААТР, ИУБ маягт, “Нас баралтын сан”д 11804 иргэний ХААТР маягт, үндсэн мэдээллийн санд бүртгэлгүй 1648 иргэний маягт, мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 3283 иргэний маягт, регистрийн дугаар хүчингүй төлөвтэй 792 иргэний маягт нийт иргэний баримтын архивт 82387 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Мөн 212 иргэний хүсэлтээр архивын баримтнаас төрөлт, гэрлэлт, нас баралтын лавлагаа шүүсэн.

Дөрөв: Бусад ажил:

➤ Иргэн, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн архивын хувийн хэргийн мэдээг сар бүр гаргаж УБТА-т хүргүүлсэн.

➤ УБЕГ-ын УБТАрхиваас ирсэн чиглэлийн дагуу устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн байгууллагын БНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж саналыг хугацаанд нь хүргүүлсэн. Архивын баримтын тоо бүртгэлийг хөтлөж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалт, ХХНЖ зэргийг гарган БНШК-ын хурлаар батлуулав.

➤ 2022 онд устгахаар ялгасан баримтуудыг УБЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу устгаж акт үйлдэн тайланг УБТАрхивт хүргүүлсэн.

➤ Тус хэлтэс нь өөрийн гэсэн байртай болсонтой холбоотойгоор архивын өрөөнд өргөтгөл хийж сунган 10 ширхэг тавиурыг хадгаламжийн санд байршуулсан. Энэ нь хадгаламжийн санд байрлаж буй хувийн хэргийн тавиурын хэрэгцээг бүрэн хангасан. Архивын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангаж архивын өрөөний гадна дотор хаалга, цонхонд камер суурьлуулан архивын цонхонд хар өнгийн хөшгийг стандартын дагуу хийж галын аюулаас хамгаалах багаж хэрэгслүүдийг шинэчлэн, утаа мэдрэгч байршуулсан. Архивын

санд хөтлөгдөх чийг дулаан хэмжигч, орсон гарсан, цэвэрлэгээ үйлчилгээн тогтмол хяналт тавьж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Арав. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

➤ 2023 онд Хяналт шалгалтын ажлын 11 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын лавлагаа олгосон бүртгэлд өдөр тутмын хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөт шалгалт 12, өргөдөл, санал, гомдлын мөрөөр 58 шалгалт хийсэн байна.

➤ Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 6326 бүртгэлд хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн 345 бүртгэлийн зөрчлийг арилгуулсан.

➤ Иргэний улсын бүртгэлийн төрсний, гэрлэсний, үрчилсний, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний, эцэг тогтоосны, нас барсны, биеийн давхцахгүй өгөгдлийн, регистрийн дугаарын, шилжилт хөдөлгөөний 751, иргэний үнэмлэхийн 247, нийт 998, архивын 5058 бүртгэлд хяналт тавьж, шалгалтаар илэрсэн 305 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажиллалаа. Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хурууны хээ зөрсөн болон бусад зөрчилтэй 13, төрсний бүртгэлд давхар бүртгэсэн 4, шилжилт хөдөлгөөний 29 бүртгэлийг тус тус хүчингүй болгосон.

➤ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 170 бүртгэлд хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн 29 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажиллалаа.

➤ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөрчил арилгасан 3, улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн 14 гэрчилгээг хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргаж, биелэлтийг хангуулж ажилласан.

➤ Хуулийн этгээдийн бүртгэлийн 100 бүртгэлд хяналт тавьж, 11 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажилласан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэхдээ архивын эх нотлох баримтаас зөрүүтэй бүртгэсэн, дутуу цахимжуулсан, хуулийн этгээдийн тамга, тэмдгээ үрэгдүүлсэн зэрэг зөрчилтэй 12 бүртгэлийн зөрчлийг арилгах дүгнэлт үйлдэж биелэлтийг хангуулж ажилласан..

➤ Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10/601 дугаартай чиглэлийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын 5000 орчим хувийн хэргээс тусгаарласан 63279 хуудас материалыг нэг бүрчлэн шалгаж, устгалд оруулсан. Архивын лавлагаа олгосон 58 бүртгэлд хяналт тавьж ажилласан.

➤ Иргэдээс ирүүлсэн 58 өргөдөл, материалыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 57 өргөдлийн дагуу холбогдох бүртгэлийг архивын эх нотлох баримттай тулган шалгаж, зөрчлийг арилгах дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн. 1 өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлсэн.

➤ Иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах, засвар өөрчлөлт оруулах, бүртгэл хүчингүй болгох, регистрийн дугаар өөрчлөх, бүртгэл сэргээн тогтоосон 71 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр 101 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан.

➤ Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 5 хоног тутамд хүргүүлэн хянуулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 316 хүн, 4 хуулийн этгээдэд нийт 9000.000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.

➤ Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Бугат, Төгрөг, Шарга, Тонхил, Дарив, Жаргалан, Баян-Уул сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг газар дээр нь хийж, иргэний улсын бүртгэлийн 123 бүртгэлийг шалгаж, 14 бүртгэлийн зөрчлийг арилгуулж, зөвлөн

тусалж ажилласан. Мөн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг 350 иргэнд суртачилж, яриа таниулга хийж ажиллалаа.

➤ Алтай, Жаргалан, Дэлгэр, Чандмань, Цогт, Цээл, Эрдэнэ, Хөхморьт, Халиун сумдын бүртгэлийн үйл ажиллагааг цахимаар шалгаж, иргэний улсын бүртгэлийн 501, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 80, архивын лавлагаа олгосон 38 бүртгэлд хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн 20 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажиллав.

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

11.1. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:

➤ 2023 онд 100,0 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс 11 сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлийн үйлчилгээний орлогоор 86.8 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 86.8% -тай байна.

11.2. Төсөв, санхүү

➤ 2023 оны 11-р сарын байдлаар 833,853,500.00 төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, 783,480,168.00 төгрөгийг зориулалтын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж ажилласан. Мөн 2023 оны төрийн хэмнэлтийн тухай хууль болон УБЕГазраас өгсөн зөвлөмжийн мөрдөн ажилласан.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт /2023 оны 11-р сарын 25-ны өдрийн байдлаар/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	655,658,100.00	655,658,100.00	0.00
Үндсэн цалин	433,230,900.00	419,871,492.00	13,359,408.00
Нэмэгдэл	171,343,200.00	172,882,360.00	-1,539,160.00
Унаа хоолны хөнгөлөлт	32,084,000.00	43,946,751.00	-11,862,751.00
Урамшуулал	19,000,000.00	18,957,497.00	42,503.00
Ажил олгогчоос нийгмийн даатгал	99,792,100.00	84,037,674.00	15,754,426.00
Тэтгэврийн даатгал	74,814,600.00	58,123,743.00	16,690,857.00
Тэтгэмжийн даатгал	7,894,100.00	6,838,087.00	1,056,013.00
ҮОМШ-ний даатгал	4,555,500.00	5,452,869.00	-897,369.00
Ажилгүйдлийн даатгал	1,139,100.00	1,238,451.00	-99,351.00
Эрүүл мэндийн даатгал	11,388,800.00	12,384,524.00	-995,724.00
Байр ашиглалттай хол тогтмол зардал	44,019,300.00	22,658,818.00	21,360,482.00
Гэрэл, цахилгаан	6,007,800.00	0	6,007,800.00
Түлш, халаалт	31,030,300.00	20,919,193.00	10,111,107.00
Цэвэр, бохир ус	5,238,000.00	0	5,238,000.00
Байрны түрээс	1,743,200.00	1,739,625.00	3,575.00
Хангамж, бараа материалын зард	14,133,000.00	9,659,040.00	4,473,960.00
Бичиг хэрэг	9,200,000.00	6,329,900.00	2,870,100.00
Тээвэр, шатахуун	1,030,000.00	0	1,030,000.00
Шуудан, холбоо, интернэт	1,375,000.00	1,180,740.00	194,260.00
Хог хаягдал зайлуулах, хортон	240,000.00	200,000.00	40,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,288,000.00	1,948,400.00	339,600.00
Эд хогшил, урсгал засварын зар	11,816,000.00	3,623,300.00	8,192,700.00
Багаж, техник, хэрэгсэл	496,000.00	0	496,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	114,600.00	125,400.00
Урсгал засвар	11,080,000.00	3,508,700.00	7,571,300.00
Дотоод албан томилолт	625,000.00	542,000.00	83,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	4,990,000.00	4,906,236.00	83,764.00
Бусад нийтлэг АҮТХураамж	490,000.00	410,000.00	80,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	148,000.00	144,236.00	3,764.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	4,308,000.00	4,308,000.00	0.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	125,000.00	0	125,000.00

Холбооны суваг ашигласны хөлс	1,980,000.00	1,815,000.00	165,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	715,000.00	580,000.00	135,000.00
Нийт дүн	833,853,500.00	783,480,168.00	50,373,332.00

11.3. Өглөг, авлагын талаар:

➤ Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд баталсан төсвийн хуваарийн дагуу явж байгаа боловч зарим зардлуудад хуваарилсан төсөв хүрэлцэхгүй байсан учир тооцоо, судалгаа гаргаж УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт сар бүр хүргүүлэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан зарим зардлуудыг өөр эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх ажлуудыг хийсэн.

➤ 2023.11.25-ны өдрийн байдлаар цалингийн 24,241,523.00 төгрөгийн өглөгтэй, ямар нэгэн авлага үүсээгүй байна.

11.4. Нэмэлт санхүүжилтын талаар:

➤ 2023 онд нэмэлт санхүүжилт аваагүй.

11.5. Аудит, хяналт шалгалтын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал, НББОУС, холбогдох хууль тогтоомж, заавар, журам мөрдөж ажилласан байдал

➤ Тус хэлтсийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Говь-Алтай аймгийн Төрийн аудитын газраас санхүүгийн аудит хийж “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өгсөн. Аудитын газраас өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг бүрэн гаргаж 2022.04.08-ны өдрийн №341 тоот албан бичгээр Төрийн аудитын газар болон УБЕГазарт хүргүүлсэн.

11.6. Тайлан мэдээ

➤ 2023 оны 11-р сарын байдлаар тус хэлтэс сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Үүнд:

1. Тус хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сарын бүрийн 2-ны өдрийн дотор Төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

2. Үнэт цаасны тайлан мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч Ц.Ганчимэгт ts.ganchimeg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

3. 2023 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор Санхүү төлөвлөлтийн газрын нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.

4. Тус хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны дотор бэлтгэн гаргаж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.

5. 1,2,3-р улирлын ХХОАТ-н тайланг гарган дараа сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

11.7. Төсвийн ил тод нээлттэй байх зарчим, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил

➤ Байгууллагын үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг хэлтсийн байрны мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

➤ 2023.10.31-ны өдрийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу <https://info.shilendans.gov.mn/> цахим хуудсанд 132 мэдээллийг хугацаанд нь байршуулсан. Огт оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд 2022 оны 4-р улирал, 2023 оны 1,2,3-р улирлын мэдээллийг хугацаанд нь илгээсэн.

11.8. Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт.

➤ 2023 оны эхэнд барилга, авто машин, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамж гэсэн 5-н бүлгийн 425,891,528.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2023.11.25-ны байдлаар 861,560,561.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй болсон.ТӨБЗГазрын 2023.05.30-ны өдрийн 279 дугаар тогтоолоор 424,962,033.00 төгрөгийн конторын барилгын 1 болон 2 давхрын хэсгийг барилга байгууламжийн дансанд орлогод авсан.

➤ ТӨБЗГазрын 2023.01.19-ны өдрийн А-1/126 тоот албан бичгээр 10,160,000.00 төгрөгийн скайнерийг тоног төхөөрөмжийн дансанд орлогод бүртгэсэн.

➤ ТӨБЗГазрын 2023.06.29-ны өдрийн А-1/1279 тоот албан бичгийн дагуу 9,000,000.00 төгрөгийн сейфийг тавилга эд хогшлын дансанд орлогод бүртгэсэн.

➤ ТӨБЗГазрын 2022.12.23-ны өдрийн А-1/2576 тоот албан бичгийн дагуу 7,573,000.00 төгрөгийн тоног төхөөрөмж, 880,000.00 төгрөгийн тавилга эд хогшил нийт 8,453,000.00 төгрөгийн үндсэн хөрөнгийг тус хэлтсийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2023 оны №01 хурлын тэмдэглэл, дүгнэлтийн дагуу акталж устгасан.

➤ 2023.09.08-ны өдрийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн УБЕГазрын санхүү аж ахуйн хэлтэст 2023.10.06-ны өдрийн 546 тоот албан бичгээр 36,367,000.00 төгрөгийн актлах хөрөнгө болон 12,047,480.00 шинэ үнэ тогтоох хөрөнгийн жагсаалтыг тус тус хүргүүлсэн.

➤ Тус хэлтэс нь орон сууцны 3 өрөө байртай ба одоогоор ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй байна.

➤ Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.

➤ Мөн Хэлтсийн даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар 2023 оны эхний хагас жилийн хөрөнгийн тооллого явуулсан.

11.9. Бараа материалын бүртгэл хөтлөлт, тайлагнасан байдал

➤ Улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг авч нэгдсэн тайланг гаргаж ажилладаг ба Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдүүлэн хяналтын улсын байцаагчаар хүчингүй болгуулан ажиллаж байна.

➤ Аж ахуйн материал, бичиг хэрэг, бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа материалын тайланг сар бүр няраваар гаргуулан хяналт тавьж ажиллалаа.

ХЯНАСАН:

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ЧҮЛТЭМЖАМЦ

ТАЙЛАН БИЧСЭН:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН

Э.БААТАРСҮРЭН